

ДАРХАН – УУЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.ХҮРЭЛБААТАР



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТЕАТРТ ЦАХИЛГААН ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ НИЙЛҮҮЛЭХ
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Гэрээний нэр: Аймгийн театрт цахилгаан хөгжмийн зэмсэг худалдан
авах Дархан-Уул, Дархан сум
дугаар: БСШУСЯ/202002496

Дархан-Уул
2020

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.03.16

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос БСШУСЯ/202002496 дугаартай, Дархан – Уул аймгийн театрт цахилгаан хөгжмийн зэмсэг нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Уг тендер нь цахим худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn сайтаар орж өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг, хувийн нууцлалын кодоор нэвтэрч www.tender.gov.mn сайтаар дамжуулан цахим хэлбэрээр ирүүлнэ.

Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 25- ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 03 дугаар сарын 25 - ны өдрийн 09 цаг 00 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газар, Удирдлагын ордон
/Аймгийн ЗДТГазар/ 1 дүгээр давхар, 105 тоот өрөө
Утас/ факс 70378104
www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ОЛГОХ ЗААВАРЧИЛГАА

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерт оролцогчдын 2018, 2019 оны санхүүгийн тайлангаас шаардлагатай мэдээллийг цахим систем ашиглан шалгана.</p> <p>Тендерт дараах материалыг ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлнэ. 2. Татвар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Харилцагч банкуудын тодорхойлолтуудыг тус тус ирүүлэх 3. Нийлүүлэх цахилгаан хөгжмийн техникийн тодорхойлолт, үнийн санал, нийлүүлэх хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. 4. 2018, 2019 оны борлуулалтын орлого нь төсөвт өртгийн дүнгээс багагүй байх 5. 2018, 2019 онуудын ижил төстэй ажил нь төсөвт өртгийн дүнгээс багагүй байна. Гүйцэтгэсэн нийлүүлэлтийн гэрээ, хүлээлгэн өгсөн акт, Захиалагчийн тодорхойлолтыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. 6. Техникийн тодорхойлолтыг бүрэн хангасан байна. 7. Захиалагчаас хавсралтаар хүргүүлж байгаа техникийн тодорхойлолтыг бүрэн хангах, төсөвт өртөгт багтаан нийлүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	<p><i>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</i></p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр</p> <p><i>Цаг: 09 цаг 00 минут</i> <i>Хялбаршуулсан цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байшин, гудамжны нэр: 14 дүгээр баг, Бурхантын хөндийн гудамж</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Нутгийн удирдлагын ордон /АЗДТГ/, 1 дүгээр давхар, 105 тоот өрөө, Аймаг, хот: Дархан-Уул аймаг, Дархан сум</p> <p>Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлнэ. 2. Нийлүүлэх цахилгаан хөгжмийн техникийн тодорхойлолт, үнийн санал, нийлүүлэх хуваарь 3. Захиалагчаас хавсралтаар хүргүүлж байгаа цахилгаан хөгжмийн техникийн тодорхойлолтыг бүрэн хангах, төсөвт өртөгт багтаан нийлүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл. <p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах</p>


	үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.
6.1.	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй, БСШУСЯ/202002496 дугаартай, цахилгаан хөгжмийн зэмсэг нийлүүлэх




Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**




БАТЛАВ
С.НАСАНБАТ
ЗАСАГ ДАРГА
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:
“Цахилгаан хөгжмийн зэмсэг нийлүүлэх”



Дархан-Уул аймаг



2020 он

№		НЭР ТӨРӨЛ, ҮЗҮҮЛЭЛТ	ТОДОРХОЙЛОЛТЫН ШААРДЛАГА	
1	Материал	Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй байна.		
2	Стандарт	Бараа, материал нь олон улсын хэмжээнд болон Монгол улсад мөрдөж буй стандартын шаардлагыг хангасан байна.		
3	Ажлын төрөл	Дархан-Уул аймгийн Залуучууд театрт Цахилгаан хөгжмийн зэмсэг нийлүүлэх ажил		
Хөгжим хэрэгсэл	Тоо ширхэг, Өнгө	Зураг	Үзүүлэлт, хэмжээ	Link
1. Yamaha тайзны тоглолтын бөмбөр	5ш бөмбөр, Басс бөмбөр 22" Жижиг бонго – 2ш (10", 12") Литавр – 16" Жижиг бөмбөр - 14" сер дугаар - 780 Өнгө – Улаан хүрэн, Үзмэн улаан		Жижиг бөмбөр - (Гүн х Диаметр): 5.5" x 14" Жижиг бонго - (Гүн х Диаметр): 7" x 10", Жижиг бонго - (Гүн х Диаметр): 8" x 12" Литавр - (Гүн х Диаметр): 15" x 16" Басс бөмбөр - (Гүн х Диаметр): 17" x 22" Бүрхүүл материал: хус Оруулсан стандартууд: HW-780 сер дугаар Хөл лүдэл: FP-7210	https://www.siveetwater.com/storer/detail/SBP2F57-CR-yamaha-stage-custom-birch-drum-set-cranberry-red


					
2.	Цангийн багц	B20 загварын цан – 4ш Хавсарга цан – 12" Акорд цан – 14" Дойл цан – 18"		Хавсарга цан – A20510 - 12" Акорд цан – A20532 14" Дойл цан – A20519 - 18" Материал: B20, Цутгамал хүрэл	https://www.sweetwater.com/store/detail/A2057911-zildjian-a-custom-box-set-14-inch-hats-16-inch-crash-20-inch-med-ride-18-inch-crash
3.	7ширхэгтэй бөмбөрийн ком микрофон	7-ширхэг Энгийн болон өсгөгчтэй микрофон; 4ш микрофоны хөл, 3ш хавчаар, 7ш XLR микрофоны залгуур		Загвар: 1 x PGA52, 1 x PGA 57, 2 x PGA81, 3 x PGA56 Микрофоны төрөл: Динамис (PGA52, PGA56, PGA57), Condenser (PGA81) Туйлын үелзэл: Кардиоид Дугаралтын дээд хэмжээ: 129.5dB SPL (PGA81) Үйлвэрлэгчийн хэсгийн дугаар: PGADRUMKIT7	https://www.sweetwater.com/store/detail/PGA52-mPack-shure-pga-drum-kit-7-complete-package

4.	<p>Басс гитарны урьдчилсан өсгөгч:</p>	<p>450W 2 x 10" 3-зурвастай EQ, Аух оролт, 15dB дэвсгэр самбар, чихэвчний гаралт, хэт өндөр / Lo ая хэлбэржүүлэлт, эффeкт давталт, шууд дамжуулалт, өндөр давтамжийн дуугуй, басс скраблер бүхий өсгөгч – Хар өнгөтэй</p>		<p>Төрөл: Хатуу төлөв Оролтын тоо: 1 Нийт хүч: 450Вт Яригч: 2ш - 10"Аmpex Custom10 EQ: 3 тохируулгын зурвастай (Ampex Ultra Hi / Lo Tone Forming) Оролт: 2 x 1/4 "(хэрэгсэл, туслах хэрэгсэл), 1 x 1/8" (аух) Гаралт: 1 x 1/4 "(чанга яригч), 1 x XLR Чихэвч: 1 x 1/8 " Өндөр: 24.8 " Өргөн: 20 " Гүн: 15 " Жин: 48 фунт.</p>	<p>https://www.sweetwater.com/storer/detail/BA210v2--ampex-ba-210v2-2x10-inch-450-watt-bass-combo-with-scrambler</p>
5.	<p>Басс гитар</p>	<p>5 утастай цахилгаан басс гитар, 2ширхэг дууны ороомогтой, Цагаан өнгөтэй Olympic White</p>		<p>Төрөл: Жааз Баруун гарын Утасны тоо: 5 утастай Өнгө: Олимпын цагаан Биеийн материал: Алдер Биеийн өнгөлгөө: Гялгар полиэстер Гар материалын: Maple Гарны хэлбэр: С профил Гарын Радиус: 12" Хурууны самбарын материал: Пау Ферро Fingerboard шилтгээ: Цагаан сүд цэцгийн Ладны тоо: 20, Дунд гүйлт Хэмжээний урт: 34" Хяналт: 1 x мастер эзлэхүүн, 1 x тогоо, 3-зурвасын идэвхтэй EQ, 1 x мини-унтраалга (идэвхтэй / идэвхгүй) Утасны төрөл: Fender USA, .045-.125</p>	<p>https://www.sweetwater.com/store/detail/IBasVDASPOWT-fender-deluxe-active-bass-v-olympic-white-with-pau-ferro-fingerboard</p>


6.	<p>Цахилгаан Соло гитар</p>	<p>6 утастай 3 төрлийн тохируулгатай цахилгаан соло гитар</p>		<p>Их биеийн төрөл: Хатуу Биеийн хэлбэр: Стратокастер Зүүн / баруун гар: Баруун гар Утасны тоо: 6 Биеийн материал: Алдер Биеийн өнгөлгөө: Гялгар поликастер Өнгө: 3 өнгөны уусгалттай Гар материал: Maple Гарны хэлбэр: Орчин үеийн C Гарны Радиус: 12" Хурууны самбарын материал: Пау Ферро Fingerboard шитгээ: Цагууд Ладны тоо: 22, Дунд гүйлт Хуваарийн урт: 25.5" Самрын өргөн: 1.6875" Самар материал: Флойд Роуз R3 түлжээ Гүүр / сүүлний хэсэг: Флойд Роузын тусгай Тааруулагчид: Fender стандарт дамжуулалт / битүүжилсэн Хүзүүний алчуур: Тоглогч цуврал Alnico V Strat Дан ороомог Дунд зэргийн пикап: Тоглогч цуврал Alnico V Strat Дан ороомог Гүүр авах: Тоглогч цуврал Alnico II Humbucker Хяналт: 1 х мастер зэлхүүч, 2 х авиа, 5 талт ирээсийг шилжүүлэх товчлуур Утасны төрөл: Fender NPS, 009-.042</p>	<p>https://www.swewater.com/store/detail/StratPFHSSP3TS--fender-player-series-stratocaster-hss-with-floyd-rose-3-tone-sunburst-with-pau-ferro-fingerboard?serial=MX19179499</p>
7.	<p>Цахилгаан соло гитарны дуу хувргач</p>	<p>6н гишгүүртэй, Ерөнхий лидалтай, COSM дууны загварчлал, USB компьютер оролттой</p>		<p>Гишгүүрийн төрөл: Олон-FX Урьдчилан тохируулга: 200 урьдчилсан тохируулга Амр загварчлал: COSM Амр загварчлалтай Оролт: 1 х багаж, 1 х TRS Эрэгтэй 1/8 "(туслах), Footswitch Гаралт: 2 х 1/4 "(үндсэн), 1 х TRS 1/4" (угас) MIDI I / O: In / Out / USB оролт гаралттай Өндөр: 4.0625" Өргөн: 21.375" Гүн: 10.6875" Жин: 10.625 фунт. Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: GT-100</p>	<p>https://www.swewater.com/store/detail/GT100--boss-gt-100-guitar-multi-effects-pedal</p>





8.	Цахилгаан гитарны урьдчилсан өсгөгч	100 ваттын 2 суваг 2x12 "гитар самнах өсгөгч, сонгогдох хүчтэй дуу чимээ, самбар дээрх эффе́кт, эффе́кт давталт, стерео ау́кс оролт, чихэвчний Jack оролттой – Хар өнгөтэй		<p>Төрөл: Хатуу төлөв Сувгийн тоо: 2 Нийт хүч: 100Вт Яригчны хэмжээ: 2 x 12" Давтамж: Тийм ээ EQ: 3 замтай Оролт: 1 x 1/4" (хэрэгсэл), 1 x 1/4" (цахилгаан өсгөгч), 1 x 1/8" (ау́х) Гаралт: 1 x 1/4" (гарах цэг) Чихэвч: 1 x 1/8" Footswitch I / O: 1 x 1/4" (суваг, эффе́кт) Footswitch орно: Тийм ээ, 2 төвчлүүртэй хөлийн шилжилт Эрчим хүчний эх үүсвэр: Стандарт IEC AC кабель Өндөр: 19" Өргөн: 26" Гүн: 10.25" Жин: 40 фунт. Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: 2330400000</p>	https://www.swewater.com/store/detail/Champ100-fender-champion-100-100-watt-2x12-inch-combo-amp
9.	Акустика гитарны урьдчилсан өсгөгч	100 ватт 2 суваг 1x8 "Bluetooth болон дижитал эффе́кт бүхий акустик гитар өсгөгч		<p>Төрөл: Акустик Амп Сувгийн тоо: 2 Нийт хүч: 100Вт Яригч: 1 x 8" спикер конус бүхий чанга яригч Оролт: 2 x XLR-1/4" комбо (микро / хэрэгсэл), 1 x 1/8" (ау́х) Гаралт: 2 x XLR (мер гарч) Чихэвч: 1 x 1/8" USB: Тийм (дамжуулалт / бичлэг) Блютуут: Тийм (аудио урсгал) EQ: 3 замтай тохируулагчтай Зориулалт: Өрөө, танхимд Ур нөлөө: Туузан цуурай, саатал, найрал дуу, вибраторон Эрчим хүчний эх үүсвэр: Стандарт IEC AC кабель Өндөр: 14" Өргөн: 18.5" Гүн: 9.25" Жин: 17.6 фунт. Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: 2314000000</p>	https://www.swewater.com/store/detail/Acoustic100-fender-acoustic-100-watt-acoustic-amp


10.	Акустика гитар	Spruce Top Бүхий 6 утас бүхий акустик- цахилгаан гитар: Зандан нуруу, хажуу, хүзүү; Плау Ферро хурууны самбар; болон Fishman Electronics - Matte Black		<p>Мөрний төрөл: Ган Утасны тоо: 6 Биеийн хэлбэр: Редондо санаа зовсон Зүүн / баруун гар: Баруун гар Өнгө: Matte Black Их бие: Хатуу Ситка Spruce Буцах ба хажуугийн мод: Хатуу зандан Гарны мод: Зандан Гарны хэлбэр: Нарийхан С Гарны Радиус: 15.75" Хурууны самбарын материал: Плау Ферро Fingerboard шигтгээ: Maple цэгүүд Цэгийн тоо: 20 Хэмжээний урт: 25.6" Утас татах чих : битүүмжилсэн никель Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: 0970813106</p>	https://www.sweetwater.com/store/detail/RedonSpruceMBK--fender-redondo-special-matte-black
11.	Цахилгаан даралтат хөгжим	Чихэвч, хөл, сандал, пидад бүхий 61 даралттай даралтат хөгжим		<p>Төрөл: Синтезаторын ажлын станц Дууны хөдөлгүүрийн төрөл (ууд): EDS-4 Аналог / Дижитал: Дижитал Даралтын тоо: 61 Даралтын төрөл: Синтетик, хурд мэдрэмтгий Бусад хянагч: Pitchbend, Mod дугуй Сансрын дэвсгэр: 16 х дэвсгэр (8 банк) Полифони: 120 тэмдэглэл (моно), 60 тэмдэглэл (стерео) Тэмдэглэлүүдийн тоо: 1075 Осцилляторууд: OSC1, OSC1 + 2 (давхар) LFO: 2 x LFO Шуултуур: 2 x Олон горимтой нэг шуултуурт Дугуй үүсгэгч: шуултуур, Амр Эффектийн тоо: 134 төрлүүд, 2 x мастер эффект, 5 x Insert эффект Sequencer: 16 мөртэй MIDI, 64 алхам, 128 дуу, 16 хэрэглэгчийн загвар дуу Дугаралтын давтамж: Нэг ширхэг бүрт 14 секундэн стерео дээж Аудио бичлэг хийх: PCM Аудио, 16 бит / 48 кГц</p>	https://www.sweetwater.com/store/detail/Kross2-61BKess--korg-kross-2-61-key-essential-bundle

			<p>Аудио тоглуулах: WAV 16 бит / 48 кГц, SD карт тоглуулах</p> <p>Сахах ой: 128MB өргөтгөл PCM санах ой</p> <p>Хадгалалт: SD / SDHC картны үүр</p> <p>Аудио оролт: 1 x 1/4 "(микро), 1 x 1/8" (шугам)</p> <p>Аудио гаралт: 2 x 1/4 "(L / Mono, R)</p> <p>Чихэвч: 1 x 1/8 "</p> <p>USB: 1 x B хэлбэрийн</p> <p>MIDI I / O: In / Out</p> <p>Пидал оруулалт: 1 x 1/4 "(дампер), 1 x 1/4" (шилжих боломжтой), 1 x 1/4" (хуваарилагдах дөрөө)</p> <p>Цахилгаан хангамж: 9V DC тэжээлийн хангамж (орсон) / 6 x AA батерей (Шүлтлэг, NiMH)</p> <p>Өндөр: 3.46" Өргөн: 36.81" Гүн: 10.59"</p> <p>Жин: 8.38 фунт.</p> <p>Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: KROSS261MB</p>	
<p>12. Цахилгаан даралтат хөгжимийн урьдчилсан өсгөгч</p>	<p>150W, 12 "Woofers, Horn Tweeter, XLR Mic оролт, стерео холбоос бүхий 4 сувгийн Цахилгаан даралтат хөгжимийн урьдчилсан өсгөгч</p>		<ul style="list-style-type: none"> • Яригчийн хэмжээ: 1 x 12" • Нийт хүч: 150Вт • EQ: 3 замын EQ • Оролт: 8 x 1/4 "(L / mono, R), 1 x XLR, 1 x 1/4" (стерео холбоос), 2 x RCA, 1 x 1/8" TRS (aux) • Гаралт: 2 x 1/4 "(L / mono, R), 1 x 1/4" (стерео холбоос), 1 x 1/4" (чихэвч), 1 x 1/4" (дэд гарчиг) • Өндөр: 18.56" • Өргөн: 19.31" • Гүн: 15.18" • Жин: 48.56 фунт. • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: KC-400 	<p>https://www.sweetwater.com/stor/e/detail/KC400--roland-kc-400-150w-12-inch-keyboard-amp</p>
<p>13. Дуу бичлэгийн хяналтын яригч</p>	<p>6.5 "Cone Woofer, 1" Dome Tweeter бүхий 95W Powered Studio Monitor, мөн ерөөний хяналт, өндөр түвшний дууны</p>		<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний тохиргоо: Би-ампед • LF яригчийн хэмжээ: 6.5" • LF яригчийн төрөл: Конус • HF яригчийн хэмжээ: 1" • HF яригчийн төрөл: Dome • LF яригчийн хүч чадал Amp: 60W • HF яригчийн хүч чадал Amp: 35W • Нийт хүч: 95 Вт • Давтамжийн хүрээ: 43Гц-30кГц 	<p>https://www.sweetwater.com/stor/e/detail/HS7--yamaha-hs7-6.5-inch-powered-studio-monitor-black</p>

		хэмжээ авах хяналтын систем (тус бүр)		<ul style="list-style-type: none"> • Кроссоверын давтамж: 2кГц • Оролтын төрөл: 1 x XLR, 1 x 1/4 "TRS • Нэвтрэх хэлбэр: Зөөврийн • Өндөр: 13.1 " • Өргөн: 8.3 " • Гүн: 11.2 " • Жин: 18.1 фунт. • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: HS7 	
14.	Хөгжим техникийн утас уртасгагч салаалагч	8 сувагын уртасгагч салаалагч , XLR оролт, гаралт могой, 25м урт – 2 ширхэг		<ul style="list-style-type: none"> • Сувууд: 8 • Холбогч 1: XLR Оролт • Холбогч 2: XLR Гаралт • Урт: 25м • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: J8CHXFBOX-XMFAN-25 	https://www.sweetwater.com/store/detail/J8FBX25-jumperz-8-channel-studio-drop-snake-25-foot
15.	Цахилгаан Басс гитарны хатуу хайрцаг	Хөнгөн цагаан хөнгөн жинтэй ABS Цахилгаан Басс бүхий гитар цутгамал, EPS хөөс тансаг, Интерьер - Хар		<ul style="list-style-type: none"> • Гитарын төрөл: Цахилгаан басс • Бүхэл бүтэн урт: 47.5 " • Int биеийн урт: 21.25 " • Биеийн гүн: 3 " • Доод захын өргөн: 13.75 " • Дунд зэргийн бутны өргөн: 13.75 " • Дээд зэргийн өргөний өргөн: 13.75 " • Гаднах урт: 49.5 " • Гаднах өргөн: 16 " • Гаднах гүн: 5.75 " • Дотоод материал: Тансаг бүрхсэн EPS хөөс • Гадаад материал: Deluxe ABS Plastic • Бариул / оосор: 1 x Бариул • Жин: 12.6 фунт. • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: GC-Басс 	https://www.sweetwater.com/store/detail/GCBass-gator-deluxe-abs-molded-case-electric-bass-guitar

16.	Цахилгаан соло гитарны хатуу хайрцаг	Хүнд даацтай хөнгөн цагааны нам даралт бүхий ABS давхар цахилгаан гитарын хайрцаг, EPS хөөс тансаг Интерьер - Хар		<ul style="list-style-type: none"> • Гитарын төрөл: Давхар цавчсан цахилгаан гитар • Дотоод нийт урт: 39.75 " • Int биеийн урт: 18.75 " • Биеийн гүн: 2.75 " • Доод захын өргөн: 12.75 " • Дунд зэргийн бутны өргөн: 12.75 " • Дээд зэргийн өргөний өргөн: 12.75 " • Гаднах урт: 40.75 " • Гаднах өргөн: 15.25 " • Гаднах гүн: 5.25 " • Дотоод материал: Тансаг бүрхсэн EPS хөөс • Гадаад материал: Deluxe ABS Plastic • Бариул / оосор: 1 х Бариул • Жин: 11 фунт. • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: GC-Electric-A 	https://www.swe.ehwater.com/store/detail/GCEleca--gator-deluxe-abs-molded-case-double-cutaway-electric-guitar
17.	Акустика гитарны хатуу хайрцаг	Тансаг доторлогоо, дагалдах хэрэгсэл, хүзүүвчний тусламжтайгаар бүрэн хатсан акустик гитар хийхэд зориулсан Hardshell хайрцаг		<ul style="list-style-type: none"> • Нийт урт: 42.5 " • Int биеийн урт: 21.25 "(өсгий үүр), 20.5" (зүгээр л бие) • Биеийн гүн: 5.5 " • Доод захын өргөн: 16.5 " • Дээд зэргийн өргөний өргөн: 13 " • Гаднах урт: 44.75 " • Гаднах өргөн: 19 " • Гаднах гүн: 7.5 " • Дотоод материал: EPS цутгасан интерьер • Бариул / оосор: 1 х Бариул • Халаас: 1 х Дотоод засал чимэглэлийн хэрэгслүүд • Жин: 8 фунт. • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: 1SKB-8 	https://www.swe.ehwater.com/store/detail/1SKB8--skb-1skb-8

18. Микрофоны залгуур утас	Микрофоны залгуур утас XLR оролт гаралтай 30м урттай 10 ширхэг утас	 <p style="text-align: right;">x10</p>	<p>turer Part Number: EXMSS-30</p> <ul style="list-style-type: none"> • Холбогч 1: XLR Оролт • Холбогч 2: XLR Гаралт • Урт: 30 м • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: EXMSS-30 	https://www.sweetwater.com/store/detail/XLR30--pro-co-exm-30-excellines-microphone-cable-30-foot
19. Аудио залгуур	1/4" TS сүмбэн, 1/4" TS сүмбэн, 20м урттай аудио залгуур 10 ширхэг	 <p style="text-align: right;">x10</p>	<ul style="list-style-type: none"> • Холбогч 1: TS оролт 1/4 • Холбогч 2: TS гаралт 1/4 • Урт: 20 м • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: EGSS-20 	https://www.sweetwater.com/store/detail/QTR20--pro-co-eg-20-excellines-instrument-cable-20-foot-straight
20. Гитарын урьдчилсан өсгөгчийн микрофон	Динамик Supercardioid гитар өсгөгч микрофон		<p>Микрофонын төрөл: Динамик/Полар хэв маяг: Суперкардиоид Хариултын хариу арга: 40Гц-18кГц/Бүтээгдэхүүний Импеданс: 350 ohm Өнгө: Хар саарал Connector: XLR/Dimensions: 5.2 "x 2.1" Жин: 0.4 фунт. Үйлдвэрлэгч Хэсгийн дугаар: 500074</p>	https://www.sweetwater.com/store/detail/E609Silver--sennheiser-e-609-silver-dynamic-supercardioid-guitar-microphone
21. Дамжуулагчийн уналтыг хамгаалагч	Тусгаарлалтын трансформатор, 15dB дэвсгэр, өргөлтийн унтраалга		<ul style="list-style-type: none"> • Төрөл: идэвхгүй DI • Субгууд: 2 • Дууны давтамж: -15dB • Оролт: 2 x 1/4 " • Гаралт: 2 x XLR, 2 x 1/4 " thru 	www.sweetwater.com/store/detail/ProD2--radial-prod2-2-channel-passive-

	бүхий идэвхгүй стерео DI	 X2	<ul style="list-style-type: none"> • Өндөр: 1.88" • Өргөн: 3.25" • Гүн: 5" • Жин: 1.95 фунт. • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: R800 1102 00 • Терөл: идэвхгүй DI • Сувгууд: 1 • Дууны давтамж: -15dB • Оролт: 1 x 1/4" • Гаралт: 1 x XLR, 1 x 1/4 "trng • Өндөр: 1.75" • Өргөн: 2.75" • Гүн: 4.25" • Жин: 1.2 фунт. • Үйлдвэрлэгчийн хэсгийн дугаар: R800 1100 00 	instrument-direct-box
22	Дамжуулагчийн уналтыг хамгаалагч	Захиалгат трансформатор ба бэхлэгээний I-цацраг бүхий идэвхгүй моно шууд хайрцаг	<p>Бүх бараа материал нь шинэ байх</p> <p>Аймгийн Залуучууд театрт цахилгаан хөгжмийн зэмсэг нийлүүлэх ажлыг 2020 оны 4,5, сард багтаан нийлүүлэхээр ажлыг зохион байгуулна.</p> <p>Тоног төхөөрөмж нийлүүлэх байгууллага нь Гадаад худалдаа эрхлэх зөвшөөрөлтэй байх</p> <p>Нийлүүлэгч байгууллага нь Захиалагчийн заасан газар /АЗДТГ/ барааг хүргэнэ. Захиалагч барааг хүлээж авч акт үйлдсэнээр санхүүжилтийг 100 хувь нийлүүлэгч талд олгоно.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалт</p> <p>30,000,000.0 төгрөг</p>	
23	Шаардлага			
24	Нийлүүлэх хугацаа			
25	Туршлага			
26	Санхүүжилт			
27	Санхүүжилтийн эх үүсвэр			
28	Нийт төсөвт өртөг			


 П.Батсүх
 Боловсруулсан: ХОХБТХ-с, аймгийн Ерөнхий эдийн засагч


Хянасан: ХОХБТХ-ийн дарга

Боловсруулсан: ХОХБТХ-с, аймгийн Ерөнхий эдийн засагч

Б Батсүх

1. **Барааны тодорхойлолт:** Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа нь шинэ , ашиглагдаагүй байна.
2. **Стандарт:** Бараа материал нь олон улсын хэмжээнд болон Монгол улсад мөрдөж буй стандартын шаардлагыг хангасан байна.
3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
4. **Бараа хүргэх газар:** АЗДТГ
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** 2020 оны 5 сард

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<i>22 нэр төрлийн хөгжмийн зэмсэгийг техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу нийлүүлэх</i>							

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.
5. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Техникийн тодорхойлолтод зааснаар] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
Техникийн тодорхойлолтод зааснаар тодорхойлогдоно.
Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
Техникийн тодорхойлолтод зааснаар |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнийн дүнгийн [0]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) ² | 9.1. Алданги оногдуулах хувь: [3]
Алдангийн нийт дүн: [Үнийн дүнгийн 5 хувиас ихгүй] |

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]